



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/317

Булган сум

Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх,  
хэрэглэх, худалдан борлуулахыг  
түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын 2026 оны А/218 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд ээлжит цэрэг татлага, цэрэг халагдах арга хэмжээ зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Булган суманд 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагаас 2026 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 15:00 цаг хүртэл архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, хэрэглэх, худалдан борлуулахыг түр хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

3.Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР